



NUM STARTUP 1.0 ХӨТӨЛБӨР ЭЛСЭЛТЭЭ АВЧ ЭХЭЛЛЭЭ

МУИС-ийн Бизнесийн сургууль, Оюутны албатай хамтран МУИС-ийн оюутнууддаа зориулан NUM Startup 1.0 сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах гэж байна. NUM Startup 1.0 хөтөлбөр нь МУИС-ийн Бизнесийн сургуулиас МУИС-ийн оюутнуудад гарааны бизнес эрхлэх онол, практикийн мэдлэг олгох зорилгоор, Кембрижийн их сургуулийн хөтөлбөртэй дүйцэхүйц агуулгаар боловсруулсан хөтөлбөр юм. МУИС-ийн оюутан нь энэхүү хөтөлбөрт суралцаж төгссөнөөр гарааны бизнес эрхлэх цогц мэдлэг, ур чадварыг эзэмшиж, сэтгэлгээг төлөвшүүлнэ.

ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- МУИС-ийн 1-4-р түвшний оюутан байх
- 2.8 буюу түүнээс дээш голч дүнтэй байх
- Гарааны бизнес эрхэлж байгаа болон эрхлэх сонирхолтой байх
- Уг хөтөлбөрт хуваарийн дагуу оролцох боломжтой байх. (Сургалт 4 сарын 6-аас 29-г хүртэл явагдах ба Пүрэв, Баасан, Бямба гаригуудад 09:00-13:00 хүртэл хичээллэнэ.)

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ:

1. Бүртгэл авах
 - Товч намтар
 - Дүнгийн тодорхойлолт
 - Бизнес санаагаа танилцуулсан 3 минутын бичлэг (Бичлэгийг гар утсаараа хийж болно.)
2. Ярилцлага
 - Ирүүлсэн материалтай танилцаж, ярилцлага авах ба шалгарсан 25 оюутныг хөтөлбөрт хамруулна.
3. Сургалт
 - 10 өдрийн онол практик хосолсон 45 цагийн сургалтанд хамрагдах ба амжилттай оролцсон багуудын бизнес санааг дэмжин ажиллана.

СУРГАЛТЫН ТӨЛБӨР: Сургалт үнэ төлбөргүй. МУИС-ийн Оюутны албанаас санхүүжүүлнэ.

БАГШ, МЕНТОР: МУИС-ийн Бизнесийн сургуулийн шилдэг судлаач багш нар хичээлийг удирдан явуулна, шилдэг бизнес эрхлэгч нар ментороор оролцоно.

ХОЛБОО БАРИХ: Хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.bcc.mn цахим хуудаснаас авна уу. Хөтөлбөрт оролцохыг хүссэн оюутнууд материалаа 2017 оны 3 сарын 29-ны дотор Бизнесийн сургуулийн Бизнес төвд (4-р байр 314 тоот) хэвлэмэл байдлаар ирүүлнэ үү. Бичлэгийг info@bcc.mn хаягаар болон материал ирүүлэхдээ файлаар ирүүлж болно.